

МУОНР-ИЙН “ХУРД” АГЕНТЛАГИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН
НЭВТРҮҮЛГИЙН ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТЭД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Г.Мэндхүү*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үг: радио өргөн нэвтрүүлэг, мэдээ, мэдээллийн хөтөлбөр, “Хурд” агентлаг

XIX зууны сүүл-XX зууны эхэн үед шинжлэх ухааны салбар бүрт олон нээлт эрдэмтэд хийж байсны нэг нь радиогийн технологи байлаа. Хүн бүр гар утсаараа Интернетийн сүлжээнд холбогдож, хүссэн мэдээллээ хайж, олж авах боломжтой өнөө үед, радиог үеэ өнгөрөөсөн хоцрогдсон мэдээллийн хэрэгсэл гэх хандлага ч ажиглагдаж байна. Гэвч радиог үл ойшоож болохгүй юм. Аливаа мэдээллийг хямд зардлаар, нэгэн цагт зэрэг олон сая хүнд шуурхай дамжуулдаг чадамжаараа радиотой эн зэрэгцэх ХМХ өнөө хэр нь байхгүй гэхэд эндүүрэл болохгүй. Радиогийн шуурхай шинж чанар нь цаг үеийн мэдээ, мэдээллийн хөтөлбөр дамжуулах үед илүү мэдрэгддэг. Монгол Улсад радиогийн өргөн нэвтрүүлгийг дамжуулдаг болсноор даруй наян нэгэн жил өнгөрчээ. Радио тогтмол нэвтрүүлэг дамжуулж эхэлсэн өдрөөс л цаг үеийн мэдээ дамжуулж иржээ. Тухайлбал, өдөр тутмын сонинд хэвлэгдсэн мэдээг нэвтрүүлэгч уншиж, олон

түмэнд сонсгож байв. Радио бол цаасгүй сонин гэж тухайн үедээ үнэлж байсан нь тохиолдлын хэрэг биш юм. Радио долгионоор цаг үеийн мэдээ дамжуулахаас гадна олон түмэнд хандсан ухуулга яриа, лекц уншуулж байжээ. Жишээ нь, 1940 оноос МАХН-ын Төв Хорооны ухуулан боловсруулах хэлтсийн шийдвэрээр радиогийн идэвхтэн лекторын групп байгуулж шинжлэх ухааны онол, түүх, олон улсын байдал, улс орны цаг үеийн зорилтын тухай сар тутам радио лекц уншдаг болсон байна. Ийм лекц нь сонсогчийн улс төрийн идэвхийг нэмэгдүүлж, ерөнхий суурь мэдлэгийг гүнзгийрүүлэхэд их үүрэг гүйцэтгэсэн юм.

Монголын радиогийн бүтэц, дотоод зохион байгуулалт наяд гаруй жилийн хугацаанд хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байдаг. Энэ өөрчлөлтөнд ажиглалт хийхэд мэдээ, мэдээллийн хөтөлбөрт хэр ач холбогдол өгч байсныг нь анзаарч болно. Жишээ нь, 1953 оны аравдугаар сарын 29-нд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 86/220 дугаар тогтоолоор Радио хорооны бүтцийг өөрчилж Улс төрийн нэвтрүүлгийн ерөнхий редакц, Уран сайхны нэвтрүүлгийн ерөнхий хэлтэс, Сур-

валжлагчдын хэлтэс, Программ ба нэвтрүүлэх хэлтэс, Техник хяналтын ба дуу бичлэгийн хэлтэс, Гадаад харилцааны хэлтэс, Аж ахуйн хэлтэс, Үндэсний хөгжмийн оркестр, Нэвтрүүлэгчийн хэлтэс гэсэн бүтэцтэй болжээ. Улс төрийн нэвтрүүлгийн ерөнхий редакцид суртал нэвтрүүлгийн, хөдөө аж ахуйн, гадаад нэвтрүүлгийн алба ордог байжээ. Өөрөөр хэлбэл радиогийн мэдээг улс төрийн нэвтрүүлгийн ерөнхий редакц бэлтгэдэг байсан гэсэн үг.

1961 оны дөрөвдүгээр сарын 12-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 163 дугаар тогтоолоор радиогийн бүтцийг нь мэдээллийн хэлтэс, нэвтрүүлгийн хэлтэс, гадаад мэдээллийн хэлтэс, программын хэлтэс, лавлах тасаг, олон улсын харилцааны хэлтэс, захидал харилцааны тасаг, “Орчин үеийн Монгол Улс” сэтгүүл, Бичиг хэргийн товчоо, техникийн хэлтэс, захиргаа гэсэн бүрэлдэхүүнтэй болгожээ. Мэдээллийн хэлтэс нь радиогийн мэдээг хариуцаж бэлтгэдэг болов. 1964 оны аравдугаар сараас “Эрин цаг, үйл явдал” гэдэг улс төр, мэдээллийн төрөлжсөн нэвтрүүлэг явуулдаг болсон. Уг нэвтрүүлгээр төр засгийн шийдвэр, үйл ажиллагаанаас гадна улс орны ажил үйлс, бүтээн байгуулалтын талаар дэлгэрэнгүй сурвалжлага, ярилцлага дамжуулдаг байжээ.

Радиогийн бүтэц, зохион байгуулалтыг дорвитой өөрчилсөн дараагийн алхам нь 1985 онд хийгдэж, мэдээллийн ерөнхий редакц бие даан байгуулагджээ. Тухайн үед радиогийн мэдээллийн ерөнхий редакц 10 сурвалжлагчтай байсан юм. 1993 оноос радиогийн мэдээллийн ерөнхий редакц нэрээ өөрчилж “Хурд” мэдээллийн агентлаг болжээ. 2005 онд олон нийтийн радио,

телевизийн тухай хууль батлагдсанаар Монголын үндэсний радиогийн түүхэнд шинэ хуудас нээгдсэн гэж хэлж болно. Олон нийтийн статустай болсноор тус радиогийн мэдээ, мэдээллийн хөтөлбөрт ч аажмаар өөрчлөлт гарч эхэлсэн юм. Өнөөдрийн байдлаар “Хурд” агентлаг нь босоо шатлалын бүтэцтэй. Үүнд: дарга, ерөнхий редактор, ахлах редактор, тоймч, редактор, сурвалжлагч. Тус агентлагт нийт 30 гаруй уран бүтээлч ажилладаг. Мөн хөдөө орон нутгийн сурвалжлагч нараас мэдээ, сурвалжлага хүлээн авдаг.

МҮОНР нь хоногт 17 цагийн турш хөтөлбөр дамжуулдаг. Үүнээс 4 цаг гаруйн хугацаанд нь “Хурд” агентлагийн уран бүтээлчдийн бэлтгэсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөр, нэвтрүүлгүүдийг дамжуулдаг. Өглөөний 06 цаг 05 минутаас үдшийн 22 цаг хүртэл цаг бүрийн эхэнд мэдээ нэвтрүүлэхээс гадна эдийн засгийн тойм, нийгэм, улс төрийн “Найм арван нэг” тойм, хууль зүйн мэдээллийн “Соёмбо” нэвтрүүлэг, “Спортын цуурай”, эрэн сурвалжлах “Баримт”, “УИХ-ын чуулганы тойм” зэрэг нэвтрүүлэг, “Сониуч микрофон” хөтөлбөр, олны анхаарал татсан асуудлаар “Онцлох сэдэв” шууд ярилцлагын нэвтрүүлгийг бэлтгэдэг. МҮОНР-ийн эфирийн нийт цагийн 23 хувийг “Хурд” агентлагийн бүтээл эзэлдэг гэж судлаач Л.Норовсүрэн 2010 онд бичиж байв. Харин 2015 оны эхний гурван улиралд МҮОНР-ийн нэвтрүүлгийн сүлжээнд ажиглалт хийхэд нийт эфирийн цагийн 18 хувийг нь “Хурд” агентлагийн бэлтгэсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөр, нэвтрүүлэг эзэлж байна.

“Хурд” мэдээллийн хөтөлбөр. МҮОНР-ийн мэдээллийн хөтөлбөр нь даваа-ням гаригт 06:10-22:00 хүртэл цаг бүрийн эхэнд нэвтэрдэг. Нэг

удаагийн үргэлжлэх хугацаа нь 5-10 минут. Эх оронд болон хилийн чанадад болсон үйл явдлын тухай мэдээ, сурвалжлагыг шуурхай дамжуулах зорилготой. “Хурд” агентлагийн мэдээллийн хөтөлбөр чанарын хувьд бусад радиотой харьцуулахад илүү боловч нэг дамжуулсан мэдээгээ 2-3 давтаж хүргэдэг.

“Монголын 7 хоног” тойм хөтөлбөр нь МҮОНР-оор ням гаригийн өглөө 11 цагаас, орой 22 цагаас нэвтэрдэг. Энэ хөтөлбөр нь өнгөрч байгаа долоо хоногт Монгол Улсад болсон чухал үйл явдлыг тоймлон хүргэдэг. Нэвтрүүлгийн үргэлжлэх хугацаа 20 минут байдаг. Тойм хөтөлбөрийг “Хурд” агентлагийн редакторууд хариуцан бэлтгэдэг.

“Дэлхийн 7 хоног” тойм хөтөлбөр нь МҮОНР-оор ням гаригт 16:00 цагаас, мөн орой 21:00 цагаас сонсогч олонд хүрдэг. Энэ хөтөлбөр дэлхий дахинд болж өнгөрсөн долоо хоногийн үйл явдлуудыг тоймлон хүргэдэг. Хөтөлбөр арван таван минут үргэлжилдэг.

Хууль зүйн мэдээллийн “Соёмбо” хөтөлбөр сонсогчдоос ирсэн захидлын дагуу хуулийн мэдээлэл өгөх зорилготой нэвтрүүлэг юм. Хууль зүйн мэдээлэл дутагдсан, эрх нь зөрчигдсэн ямар ч хүнд мэргэжлийн хуульчийн зөвлөгөөг сонсгодог. Энэ төрлийн радиогийн хөтөлбөр тун ховор байдаг. Тиймээс энэ нь өнөө үед цаг үеэ олсон нэвтрүүлэг гэж үзэж болно. Хууль зүйн мэдээллийн “Соёмбо” хөтөлбөр Даваа гаригийн өглөө 9:10 цагт орой 21:10 (давталт), Мягмар гаригт 10:40

(давталт), Баасан гаригийн өглөө 9:10, оройн 21:25 (давталт) цагаас сонсогчдод хүрдэг. Ингэж хөтөлбөрийнхөө нэг дугаарыг олон дахин давтах нь сонсогчдыг залхаах нөхцөл болно гэж үзэж болох юм. Тухайлбал: даваа гаригийн өглөөний 8:00 цагийн дугаарыг орой нь, бас маргааш нь гээд нийт 3 удаа давтаж байгаа юм. Баасан гаригийн дугаар нь бусдаасаа өвөрмөц онцлогтой. Сонсогчидтой утсаар хол-

богдон тэдний асуултанд тухайн дугаарын зочин хариулт өгөх хэлбэрээр хөтөлбөр үргэлжилдэг. Хөтөлбөрийн энэ хэлбэр нь сонсогчдод илүү хүртээмжтэй, өгөөжтэй байдаг гэж хэлж болно.

Улс төр мэдээллийн “Найм арван нэг” тоймчийн хөтөлбөр нь дотоодод

болж байгаа улс төр, төр засаг, эдийн засгийн тухай мэдээллийг даваа, мягмар, пүрэв, баасан гаригт өглөө 8:00, 11:00 (давталт) цагаас шуурхай хүрдэг. Энэ хөтөлбөрийн хувьд төр засгаас гаргаж байгаа хууль, эдийн засгийн өнөөгийн байдлын талаар цаг алдалгүй зөв цэгцтэй байдлаар сонсогчдод хүргэж чаддаг ч давталтын хугацаа ойрхон байгаа нь сул тал юм. Хөтөлбөр 10-15 минутын хооронд үргэлжилдэг.

“Тусгал” мэдээллийн шууд хөтөлбөрийг МҮОНТ-ийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөртэй адилтгаж болох өргөн хэмжээний нэвтрүүлэг гэж “Хурд” агентлагийн сэтгүүлчид ярьдаг. Хөтөлбөрөөр мэдээ дамжуулдаггүй, харин цаг үеийн асуудлуудаар бэлтгэсэн сурвалжлага хүргэж, нийгэмд



Цаг үеийн хандлага, орчин үеийн нийгмийн шаардлага, сонсогчдын мэдээлэл хүлээн авах арга зэргийг “Хурд” агентлагийн уран бүтээлчид соргогоор мэдэрч, цаг тутмын мэдээ дамжуулахдаа хэлбэрийг ч эрэлхийлж, эрс шинэчлэлийг хийж чаджээ



тулгамдаж байгаа сэдвээр зочин урьж ярилцах хэлбэрээр нэвтрүүлэг өрнөдөг. Нийт 30 гаруй минут үргэлжилдэг МҮОНР-ийн томоохон мэдээллийн хөтөлбөрүүдийн нэг хэлж болно. Цагийн хуваарийн хувьд (Даваа-Пүрэв) гаригуудад оройн 18:00, үдшийн 22-00 (давталт) цагт МҮОНР-ийн нэгдүгээр сувгаар нэвтэрдэг.

“Баримт” эрэн сурвалжлах нэвтрүүлэг нь хууль бус үйл ажиллагааг илрүүлж олон нийтэд мэдээлдэг МҮОНР-ийн цорын ганц эрэн сурвалжлах нэвтрүүлэг гэдгээрээ бусдаас онцлог юм. Энэ нэвтрүүлэг нь 2012 онд Ц. Балдоржийн нэрэмжит шилдэг бүтээлийн шагнал хүртсэн байдаг. Сонсогчдод хүрэх цагийн хувьд лхагва гаригийн өглөө 08:00, 11:00 цагаас дамждаг.

Онцлох сэдэв: шууд нэвтрүүлэг нь “Тусгал” хөтөлбөрийн нэгэн адил мөн сурвалжлага, тулгамдсан асуудлаарх зочны ярилцлагаас бүрддэг. Нэвтрүүлгийн үргэлжлэх хугацаа гучин минут. Дээрх хөтөлбөрөөс цагийн хуваариар ялгарна: баасан гаригт 14:10, үдшийн 22:00 (давталт) цагаас хүрдэг. Мөн асуудал дэвшүүлсэн байдлаараа “Тусгал” хөтөлбөрөөс ялгардаг.

Сүүлийн жилүүдэд МҮОНР-ийн мэдээ, мэдээллийн хөтөлбөрт агуулгын төдийгүй хэлбэрийн өөрчлөлт ч гарч байгааг дурдах нь зүйтэй юм. Тухайлбал, радиогийн цаг тутмын мэдээг нэвтрүүлэгчээр уншуулахаас татгалзаж, студид ахлах редактор нь ажиллаж, мэдээ танилцуулж байна. Мөн мэдээний цагаар тухайн үйл явдал өрнөж байгаа газраас сурвалжлагч утсаар холбогдож шууд эфирт тайлбар, баримт мэдээлэл дамжуулж байна. Өөрөөр хэлбэл, МҮОНР-ийн мэдээ дамжуулж байгаа аргачлал нь үндсээрээ өөрчлөгджээ. МҮОНР-ийн

“Хурд” агентлагийн энэ туршлагыг МҮОНТ-ийн “ММ” агентлагийн уран бүтээлчид ч ажилдаа нэвтрүүлж эхэлсэн юм.

МҮОНР-ийн “Хурд” агентлагийн бэлтгэн нэвтрүүлдэг мэдээ, мэдээллийн хөтөлбөрт гарсан өөрчлөлт, шинэчлэлтийг ажигласны эцэст дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

— МҮОНР-ийн “Хурд” агентлаг нь улс оронд болон хилийн чанадад болж байгаа үйл явдал, үзэгдлийн тухай мэдээг тогтмол цагт шуурхай дамжуулж, өмнөө тавьсан зорилгоо сайн гүйцэтгэж байна.

— “Хурд” агентлаг үйл ажиллагаагаа зөвхөн мэдээ дамжуулах төдийхнөөр хязгаарлаагүй. Улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүй гээд нийгмийн амьдралын олон талт асуудлыг тусгасан, эрэн сурвалжилсан, асуудал дэвшүүлсэн, хөтөлбөр, нэвтрүүлгийг мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэж байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бусад радиостанцууд МҮОНР-той өрсөлдөх хэмжээнд чанартай нэвтрүүлэг бэлтгэж чадахгүй байгаа юм.

— Цаг үеийн хандлага, орчин үеийн нийгмийн шаардлага, сонсогчдын мэдээлэл хүлээн авах арга зэргийг “Хурд” агентлагийн уран бүтээлчид соргоогоор мэдэрч, цаг тутмын мэдээ дамжуулахдаа хэлбэрийг ч эрэлхийлж, эрс шинэчлэлийг хийж чаджээ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Амарзаяа Л.* 2009. Радио сонсох урлаг. УБ.
2. *Амарзаяа Л.* 2009. Хөтлөгчийн соёл УБ.
3. *Андерсон Х.* нар. 2008. Нийтлэл нэвтрүүлгийг яаж бэлтгэх вэ? УБ.
4. *Батжаргал Д., Мэндхүү Г.* 2015. Радиогийн тухай А-Я хүртэл УБ.
5. *Дагиймаа Д.* 2009. Радио сэтгүүл зүйн үндэс. УБ.

6. *Мэндхүү Г., Өнөрсайхан Т.* 2014. Мэргэжлийн телевиз. УБ.

7. *Мэндхүү Г., Өнөрсайхан Т.* 2014. Телевизийн тухай. А-гаас Я хүртэл. УБ.

8. *Норовсүрэн Л.* 2010. Радио сэтгүүл зүй. УБ.

9. *Норовсүрэн Л.* 2012. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Дэд боть. Хоёр дахь хэвлэл. УБ.

10. *Норовсүрэн Л., Зулькафиль М., Чойсамба Ч.* 2013. Монголын сэтгүүл зүй-100 жил: хамгийн, хамгийн, хамгийн. УБ.

11. *Шаравдорж Н.* 1994. Монголын радио түүхэн замналын товч хуанли. УБ.

Резюме

Автор рассматривает процесс становления и развития новостных программ Общественного радио Монголии. В статье автором анализируется выпуск новостей и другие информационные программы общественного радио и даётся краткое описание популярных передач агентства “Хурд”. Опираясь на результаты исследования, автор пришёл к выводу, что информационные программы Общественного радио Монголии являются примером высокого журналистского мастерства.